



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ

2024 оны 04 сарын 29

Дугаар 09/6

Мандалговь хот

“ЗЕДПРОЖЕКТ” ХХК-д

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил, нэр: Дундговь аймаг Эрдэнэдалай сумын 7 дугаар багийн нутагт дэвсгэрт байрлах 640 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөл.
2. Зургийн шифр, зураг төслийн компани: ЗП-23-37-180 “ЗЕДПРОЖЕКТ” ХХК
3. Барилга байгууламжийн зориулалт, захирамж: Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/139 шийдвэртэй, Аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн ажлын даалгавартай.
4. Барилга байгууламжийн давхар, талбай: 3 давхар, 15600 м.кв2
5. Галд тэсвэршилтийн зэрэг: II
6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф1.1
7. Зургийн иж бүрдэл: 7 хэсэг

**Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн
галын аюулгүй байдлын дүгнэлт**

1. Барилгын хананы гадна дулаалгын материалд ШҮ үзүүлэлттэй барилгын материалыг ашиглах ба шинжилгээнд оруулсан дүгнэлттэй байх. /ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс авсан/.
2. Гал гарсан үед ашиглах галын гадна гидрант заавал байхаар тооцож төлөвлөх.
3. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн заавал биелүүлэх 4 дүгээр хавсралтад заасан гал тусгаарлах хамгаалалтын зай хэмжээг баримтлах.
4. Галын дохиоллын хүлээн авагч станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах. /БНБД 21-04-05/

482423032

5. 3 давхарын гарах чиглэлийн хаалгыг гадагш тийш онгойж байхаар төлөвлөх.

Дээрх шаардлагын дагуу ажлын зургийг засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаар;лагатай.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2024.04.29	Нүүр хуудас, БА-03-07, ХТ-24, ХАС-22,23,24,25,26,ХД-12,13,14,15,ЦБУ-03,04,05	Барилгын ажлын зураг төслийг дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН
БАЙЦААГЧ, АХМАД Ч.НАЦАГДОРЖ





ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14210,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41,
цахим шуудан: letter@moh.gov.mn,
цахим хуудас: http://www.moh.mn

2024.05.24 № 10-00-02/005/152

Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 5.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн салбарын хяналтын газрын даргын баталсан Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2024 оны 10-00/02 дугаартай удирдамжийг үндэслэн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг дэвсгэрт төлөвлөгдөж буй "640 суудалтай сургуулийн барилга"-ын ажлын зураг төсөл, зурагт дагалдах баримт бичигт эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:

Дундговь аймгийн ерөнхий архитекторын баталсан 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн АТД-48-92/23 дугаартай архитектор төлөвлөлтийн даалгавар, Дундговь аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн ЗД-2024/25 дугаартай "Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 640 суудалтай сургуулийн барилгын" ажлын зураг төсөл боловсруулах даалгавар, загвар зургийг үндэслэн ажлын зураг төслийг боловсруулсан байна.

Барилга архитектур, технологийн байгуулалт, барилга бүтээц, ерөнхий төлөвлөгөө, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, гадна цахилгаан, холбоо дохиолол,

гадна холбоо дохиолол, гадна дулаан, дулаан механик, халаалт, агаар сэлгэлт, ус хангамж ариутгах татуурга, цэвэр бохир усны ажлын зураг төслийг барилгын зураг төслийн "Зэдпрожект" ХХК-д 2024 онд боловсруулсан. Ажлын зургийн шифр ЗП-23-37-180.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ерөнхий боловсролын сургууль (9034706 регистрийн дугаартай) сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А04 дугаартай захирамжийг үндэслэн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Төв 7 дугаар баг, Өвөр утаал 1 гудамжны 100 тоот хаягт 4815000696 нэгж талбарын дугаартай, Боловсролын байгууллага зориулалттай, 63223 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн, эзэмших эрхийн №0000075815 гэрчилгээтэй. Эрхийн улсын бүртгэлийн дугаар Э-0813000013.

Зураг төслийн товч агуулга:

Төлөвлөж буй сургуулийн барилга нь тэнхлэгээрээ 54.5x51.8 м хэмжээтэй, Н хэлбэртэй,

зоорьтой, 3 давхар, цутгамал төмөр бетон каркас хийцтэй, хөнгөн блок дүүргэгч ханатай, төмөр бетон хучилттай, хавтгай төмөр бетон дээвэртэй байхаар;

Барилга нь А; В; В1; С; D гэсэн 5 блокоос бүрдэх бөгөөд В; В1 блок нь Х1-Х4, Х9-Х12 тэнхлэгийн хооронд зоорьгүй 3 давхар, А блок Y7-Y11 тэнхлэгийн хооронд зоорьгүй 3 давхар бөгөөд 3 давхартаа соёлын танхимтай ба хучилт нь металл дам нуруутай сендвич хавтан байхаар;

С блок нь зоорьтой 3 давхар, D блок нь спорт заал ба заалны хучилт нь металл дам нуруутай сендвич хавтан байхаар төлөвлөсөн байна.

Зоорийн давхарт: гол шат, коридор, өлгүүр, агуулах, цахилгааны өрөө, холбооны өрөө, техникийн өрөө;

Нэгдүгээр давхарт: Бага бүлгийн 52.46 м², 51.78 м², 67.81 м², 67.71 м² талбайтай 4 анги, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ариун цэврийн өрөөнүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө, цайны газар, хуурай агуулах, сав суулга угаалгын өрөө, хөргүүрт агуулах, хоол бэлтгэлийн өрөө, гал тогоо, багш нарын хооллох хэсэг, коридор, эмчийн өрөө, тусгаарлах хэсэг, гол шат, ажилчдын хувцас солих болон ариун цэврийн өрөө, эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө, 472.44 м² талбайтай спорт заал, биеийн тамирын багшийн өрөө, хөдөлмөрийн 2 кабинет, хичээл бэлтгэлийн өрөө, вестибюль, гол орц, хуурай агуулах;

Хоёрдугаар давхарт: Уран зохиолын, түүх нийгмийн, физикийн, монгол хэлний, математикийн, шугам зургийн кабинетууд, биологийн кабинет хичээл бэлтгэлийн өрөө, химийн лаборатори хичээл бэлтгэлийн өрөө, номын фонд, уншлагын танхим, спорт заалны үргэлжлэл, алдрын танхим, багш нарын өрөө, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ариун цэврийн өрөөнүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө, ажилчдын ариун цэврийн өрөө, рекреацийн хэсэг, гол шат, хичээлийн эрхлэгчийн өрөө, санхүү болон нягтлангийн өрөө, захирлын туслах, захирлын өрөө;

Гуравдугаар давхарт: Ахлах бүлгийн 54.04 м², 53.26 м², 51.67 м² талбайтай 3 анги, хичээл бэлтгэлийн өрөө, иргэний хамгаалалтын, газарзүйн, компьютерийн кабинетууд, гадаад хэлний 2 кабинет, хичээл бэлтгэлийн өрөө, 228.71 м² талбайтай соёлын танхим, дугуйлан, багшийн өрөө, тайз, бэлтгэлийн 2 өрөө, коридор, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ариун цэврийн өрөөнүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө, рекреацийн хэсэг, шат байхаар тус тус төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлт: Барилгын өрөөний зориулалтаас хамааран агаар сэлгэлтийн механик болон ердийн систем төлөвлөсөн. Барилгын анги танхимд агаар сорох ердийн систем байхаар, ариун цэврийн өрөөнүүд, гал тогоо, соёлын танхим, хооллох заал, спорт заал, хувцас солих өрөө зэрэгт агаар сорох механик систем байхаар, соёлын танхим, хооллох заал, спорт зааланд агаар оруулах механик систем байхаар тус тус төлөвлөсөн байна.

Дулаан, ус хангамж, ариутгах татуурга: “Үлэмж хурд” ХХК-ийн захирлын баталсан 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн УХ-04/2024 дугаартай техникийн нөхцөл гаргуулсан.

Цахилгаан хангамж: Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын баталсан 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 24/01 дугаартай техникийн нөхцөл гаргуулсан.

Холбоо мэдээлэл: Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Дундговь аймгийн газрын даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн В-А2024/01 дугаартай техникийн нөхцөлтэй.

Инженер геологийн судалгааны талаар: Архивын № ДуГ-07/22, ЗТ11-135/22 дугаартай Барнаб ХХК-д хийгдсэн инженер геологийн судалгааны дүгнэлттэй. Барилгажих талбай нь газар чичирхийллийн 7 баллын бүсэд байрласан. Судалгаагаар инженер-геологийн төвөгшлийн ангиллаар дунд зэргийн нөхцөлтэй, хөрсний ус илрээгүй байна.

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ДҮГНЭХ НЬ:

Хоол бэлтгэх өрөөнд бохир ус зайлуулах сүлжээнд өөх, тос баригчийг, хоолны газрын угаалга ба бэлтгэлийн өрөө, шүршүүр, ариун цэврийн өрөөний шаланд ус зайлуулах трап тус тус төлөвлөх;

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг дэвсгэрт төлөвлөгдөж буй "640 суудалтай сургуулийн барилга"-ын ажлын зураг төсөл төлөвлөлт нь Олон нийт, иргэний барилга төлөвлөлт БНБД 31-03-03, "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал.Ерөнхий шаардлага" MNS 6782:2019 стандарт, "Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага" MNS 6799:2019 стандартад заасан эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛДЫН АНХ

ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН



[Handwritten signature] Н.НАНДИНЦЭЦЭГ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ЗЭДПРОЖЕКТ ХХК-ИЙН

ТӨЛӨӨЛӨЛ



[Handwritten signature]